



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/157

Хэрлэн сум

Чадавх бэхжүүлэх баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газар болон Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооройд 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан "Тогтвортой амьжиргаа III" төслийн санхүүжилтийн хэлэлцээр, Сангийн сайдын 2015 оны 7-р сарын 10-ны өдрийн 196 тоот тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тогтвортой амьжиргаа III төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 069 тоот албан хүсэлтийн дагуу төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Аймгийн чадавх бэхжүүлэх багийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ж.Ганбаатар	-ЗДТГ-ын дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Даваасүрэн	-Төслийн орон нутгийн ажилтан
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Цэцэгсүрэн	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Үнэнбат	-ОНӨГ-ын ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Чадавх бэхжүүлэх багийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах, сумдын чадавхийг бэхжүүлэх онцлог хэрэгцээг сум бүрээр тодорхойлж, аймгийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг багийн ахлагч /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 732